



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 02 дугаар сарын 29

Дугаар 18/05

Баян-Өндөр сум

**Газрыг улсын тусгай хэрэгцээнд
авах саналын тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 287 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Орхон аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт харьяалагдах хавсралт зурагт заагдсан 4230,1 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсүгэй.

2. Тогтоолыг холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ